

ЭКОНОМИКСИЙН ЦАГААН ТОЛГОЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ?

УЛСЫН XVII ОЛИМПИАДЫН ХОЁРДУГААР ШАТ: МИКРО ЭДИЙН ЗАСАГ

2024-05-05

БОДЛОГО №1(10 ОНОО)

Ухаалаг утас импортлодог жижиг улс болох А улсыг авч үзье. Ухаалаг утасны дотоодын зах зээлийн эрэлтийн функц $Q_D = 1000 - 20P$, нийлүүлэлтийн функц $Q_S = -200 + 30P$ ба дэлхийн зах зээлийн үнэ 18 нэгж бол

- А улсын ухаалаг утасны импортын хэмжээ хэд вэ? (2 ОНОО)
- А улсын ухаалаг утасны импортын эрэлтийн функцыг бичиж муруйг байгуул. (3 ОНОО)
- А улсын засгийн газар дотоодын ухаалаг утасны үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор сард 100 ухаалаг утас импортлох квот тогтоосон бол нийгмийн алдагдал (DWL)-ыг гарфикаар харуулж, хэмжээг тооцоол. (5 ОНОО)

Бодолт

- Дэлхийн зах зээлийн үнээр дотоодын хэрэглэгчдийн эрэлтийн хэмжээ:

$$Q_D = 1000 - 20 \cdot 18 = 640$$

Дэлхийн зах зээлийн үнээр дотоодын нийлүүлэлтийн хэмжээ:

$$Q_S = -200 + 30 \cdot 18 = 340$$


А улсын ухаалаг утасны импортын хэмжээ:

$$M = Q_D - Q_S = 300$$

- Импортын эрэлтийн функцыг эрэлт нийлүүлэлтийн функцын ялгавраар олно:

$$Q_{MD} = Q_D - Q_S = 1000 - 20P - (-200 + 30P) = 1200 - 50P \text{ эсвэл } P = 24 - Q_{MD}/50$$

График:



- Засгийн газар квот тогтоосноор дотоодын нийлүүлэлтийг квотын хэмжээгээр нэмэгдүүлнэ буюу графикт нийлүүлэлтийн S муруй баруун доош шилжинэ:


$$Q_S^{quota} = -200 + 30P + 100 = -100 + 30P$$

Квот тогтоосноор дотоодод ухаалаг утасны үнэ нэмэгдэнэ: $Q_S^{quota} = Q_D \Rightarrow P^{quota} = 22$

Үнэ 18-аас 22 болж нэмэгдсэнээр дотоодын ухаалаг утасны эрэлт $Q_D^{quota} = 1000 - 20 \cdot 22 = 560$ болж буурна, харин нийлүүлэлт $Q_S^{quota} = -200 + 30 \cdot 22 = 460$ болж өснө.

Улмаар графикт дүрсэлсэн хоёр жижиг гурвалжны талбайтай тэнцүү нийгмийн алдагдал (DWL) үүснэ. Нийгмийн алдагдлыг тооцвол: $DWL = (4 \cdot 120)/2 + (4 \cdot 80)/2 = 400$

График:



Бэлтгэсэн: Эдийн засгийн тэнхимийн ахлах багш,

Доктор Б.Энхмаа

БОДЛОГО №2(10 ОНОО)

Нэгэн төрийн бус байгууллага дараах мэдэгдлийг гаргажээ. “Агаарын тээврийн компаниудын санал болгож буй үнэ маш олон янз байгаа нь шударга бус байна. Маш их ашиг хийж байна. Жишээ нь МИАТ компани хоёр дахь Боинг 787-9 онгоцоо өнөөдөр хүлээн авлаа. Шинэ авсан Боинг 787 маркийн онгоцоороо АНУ-руу тээвэрлэлт хийхдээ тус онгоцонд суусан бүх зорчигчид өөр хоорондоо ялгаатай байж болохоор үнэ төлдөг тогтолцоо одоо үйлчилж байна. Энэ нь шударга бус бөгөөд үр ашиггүй нь ойлгомжтой. Иймээс бид агаарын тээврийн компаниуд нэг онгоцоор зорчиж буй хүмүүсээс ижил хэмжээтэй төлбөр төлдөг байх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Нэгэнт л нэг онгоцоор нэг газраас цугтаа нисэж, өөр нэгэн газар очиж байгаа юм чинь бүгдээрээ ижилхэн төлье. Агаарын тээврийн компаниуд хэтэрхий их шулж байна, хууль гаргаж онгоцны тасалбарын үнийг зорчигч бүрийн хувьд ижил байхаар тогтоодог эрхзүйн орчин бүрдүүлэх нь зүйтэй. Хууль санаачлая.” Мэдэгдэлд үндэслэн дараах асуултуудад хариулж бичнэ үү.

1. Агаарын тээврийн компаниуд нислэгийн үнээ тогтоохдоо хэрэглэгчийн төлөхөд бэлэн байдал (willingness to pay) -д үндэслэн тогтоож байгааг экономикст хэрхэн нэрлэдэг вэ? (2 ОНОО)

2. Тухайн нислэгийн тасалбарыг худалдан авч буй хэрэглэгчдийн төлж буй үнийг агаарын тээврийн компани ялгаатай тогтоох боломжит хувилбаруудаас 5 жишээ бичнэ үү. Жишээ бүрд нэг өгүүлбэрээр тайлбар бичих. **(5 ОНОО)**
3. Энэ төрлийн үнэ тогтоох механизм ашиглан агаарын тээврийн компаниуд ашгаа нэмэгдүүлж байгаа нь нийгмийн зардлыг (social cost) нэмэгдүүлэх үү? Яагаад? **(3 ОНОО)**

Хариулт

1. **Үнийн ялгаварлал** (Price Discrimination)
2. **5 жишээ бичих.**
насаар (2 хүртэл настай хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хямд гэдэг ч юм уу), **дамжин нислэгээр** (хоёр талдаа нэг компанийн нислэгийг авч буй бол хямд гэх мэт), **Хоёр талын тасалбар авах, цонхон тал ба гудам талын суудал, нэмэлт үйлчилгээ авах** (хөнжил, дэр, аюулгүйн гарцад ойр суудал гэх мэт), **урьдчилан захиалсан хугацаагаар** (эрт захиалах нь эцсийн мөч хүртэл илүү үнэтэй байж болно, тэр үед дахин хямдрах болно), **бүлгээр зорчигчдод хямд байх** гэх мэт... so so so many
3. Үнийн ялгаварлалаас үүсэж буй хэрэглэгч бүрээр төлөхөд бэлэн байдалд (WTP) үндэслэж байгаа тул хэрэглэгчийн илүүдлээс зарим хэсэг нь үйлдвэрлэгчийн илүүдэлд шилжиж байгаа хэлбэр юм. Нийгмийн зардал нэмэлтээр үүсэхгүй.

*Бэлтгэсэн: Эдийн засгийн тэнхимийн ахлах багш,
Магистр С. Амартүвшин*